**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Ерөнхий боловсролын 84 дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: НТАГ-2026/299/НА-СТА-ТШ3**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2026 он | Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр<br>Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br>Аудитын менежер Я.Алтанцэцэг<br>Утас: 325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Н.Баттогоо<br>Утас: 325093 Цахим хаяг: battogoon@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.02.25 № 168

танай ______ -ны № ______ -т

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 84 ДҮГЭЭР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
А.ГАНТУЛГА ТАНАА

## Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн ерөнхий боловсролын 84 дүгээр сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус сургууль нь Нийслэлийн Боловсролын газрын баталсан хөтөлбөрийн дагуу 6 дугаар ангиас эхлэн математик, англи хэлд суурилсан цахим хөтөлбөрийг хэрэгжүүлж, суралцагчид олон улсын түвшин тогтоох шалгалтыг 10 дугаар ангиасаа өгч, сургууль төгсөхдөө сурагчдын 30 гаруй хувь нь дээд түвшин хангаж, дотоод, гадаадын их дээд сургуульд тэтгэлгээр суралцаж байна.

### Аудитын гол асуудал

Багш, сурагчдын ажиллах суралцах орчныг бүрдүүлэх, олон улсын сургалтын аргуудыг нутагшуулах, цахим орчинд зөв зохистой ажиллуулах зэрэг олон нөхцөлийг бүрдүүлж 14 танхимд 183.1 сая төгрөгийн сүүлийн үеийн ухаалаг самбар, сургуулийн 2 давхрын эзэмшлийн талбайг 83.0 сая төгрөгөөр иж бүрэн зассан байна.

### Бусад асуудал

Нийслэлийн ерөнхий боловсролын 84 дүгээр сургуулийн 2025 оны гүйцэтгэлийн тайланг 5 агуулгын хүрээнд 23 зорилт, 58 арга хэмжээг төлөвлөн 87.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

1426050195

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

C:\Users\narangua.j\Desktop\Бичиг хэрэг 2026\2026\word\ywsan bichig\2026.02.25 Dugnelt -.docx

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Тодруулга | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | | **1,891,953,120.3** | **925,496,500.4** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 4 | 1,466,414,216.2 | 613,856,674.4 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | | 1,466,414,216.2 | 613,856,674.4 |
| **3121** | **Төгрөг** | | 1,466,414,216.2 | 613,856,674.4 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | | 1,466,414,216.2 | 613,856,674.4 |
| **33** | **АВЛАГА** | 5 | 26,195,584.4 | 1,281,732.4 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | | 401,232.9 | 1,281,732.4 |
| **335** | **Бусад авлага** | | 25,794,351.6 | - |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | | 25,794,351.6 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 6 | 399,343,319.7 | 310,358,093.7 |
| **351** | **Түүхий эд материал** | | 330,646,698.6 | 282,961,290.7 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | | 330,586,698.6 | 282,288,883.7 |
| 35130 | Эм боох материал | | 60,000.0 | 672,407.0 |
| **354** | **Хангамжийн материал** | | 68,696,621.1 | 27,396,803.0 |
| 35410 | Бичиг хэргийн материал | | - | 868,260.0 |
| 35420 | Аж ахуйн материал | | 6,885,000.0 | 8,036,980.0 |
| 35470 | Бусад хангамжийн материал | | 61,811,621.1 | 18,491,563.0 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | | **10,956,297,901.0** | **10,541,880,122.5** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 7 | 10,956,297,901.0 | 10,541,880,122.5 |
| **392** | **Биет хөрөнгө** | | 10,434,429,441.0 | 10,020,432,602.5 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | | 11,165,125,622.3 | 11,165,125,622.3 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | | (2,132,267,960.3) | (2,480,714,570.8) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | | 1,400,432,897.9 | 1,496,732,502.2 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | | (647,786,715.4) | (708,069,861.0) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | | 790,795,598.0 | 804,400,360.1 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | | (361,306,967.3) | (422,294,920.9) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | | 12,640,000.0 | 12,640,000.0 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | | (600,000.0) | (4,613,333.3) |
| 39217 | Ном | | 207,396,965.7 | 157,226,803.8 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | | 521,868,460.0 | 521,447,520.0 |
| 39301 | Програм хангамж | | 12,206,300.0 | 1,350,000.0 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | | (12,206,300.0) | (1,350,000.0) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | | 521,868,460.0 | 521,447,520.0 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | | **12,848,251,021.3** | **11,467,376,622.9** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | | **12,848,251,021.3** | **11,467,376,622.9** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | | 12,848,251,021.3 | 11,467,376,622.9 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | | 2,227,046,476.6 | 2,227,046,476.6 |
| 51101 | Өмч:- төрийн | | 2,227,046,476.6 | 2,227,046,476.6 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | | 3,482,577,788.7 | 2,103,282,199.4 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | | 3,482,577,788.7 | 3,458,753,319.7 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | - | (1,355,471,120.4) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 7,138,626,756.0 | 7,137,047,946.9 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | | **12,848,251,021.3** | **11,467,376,622.9** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Тодруулга | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | **9,344,103,524.8** | **8,903,003,104.0** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | | 9,017,046,500.0 | 8,629,831,900.0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 9,017,046,500.0 | 8,629,831,900.0 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | | 327,057,024.8 | 273,171,204.0 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | | 327,057,024.8 | 273,171,204.0 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | | **762,546,937.2** | **484,228,518.9** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | | 762,546,937.2 | 484,228,518.9 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | | 762,546,937.2 | 484,228,518.9 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 220,734,841.0 | 345,413,276.0 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 65,090,300.0 | 29,689,646.0 |
| 1200017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | | 283,558,304.2 | 74,885,611.7 |
| 1200018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | | 193,163,492.0 | 34,239,985.2 |
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2** | **10,106,650,461.9** | **9,387,231,622.9** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **9,636,306,623.6** | **10,684,738,972.6** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 8,911,086,623.6 | 9,944,138,972.6 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | 6,297,329,728.8 | 7,502,336,673.7 |
| 210101 | Үндсэн цалин | | 4,191,116,459.4 | 4,826,033,873.1 |
| 210102 | Нэмэгдэл | | 1,571,816,659.4 | 1,790,530,625.6 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 104,327,500.0 | 417,792,000.0 |
| 210104 | Урамшуулал | | 430,069,110.0 | 467,980,175.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | 791,392,809.5 | 939,577,064.5 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 545,104,866.8 | 644,757,441.6 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 64,947,962.5 | 78,258,912.7 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 32,308,892.5 | 38,917,146.5 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 29,796,117.5 | 35,500,801.1 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 119,234,970.2 | 142,142,762.5 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | 232,057,064.8 | 263,172,704.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 88,141,912.8 | 108,499,981.7 |
| 210302 | Түлш, халаалт | | 56,602,720.6 | 64,490,044.7 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 87,312,431.3 | 90,182,677.6 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | - | 79,624,023.4 |
| 210404 | Ном, хэвлэл | | - | 26,203,711.2 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | | - | 53,420,312.2 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 132,719,210.0 | 4,998,500.0 |
| 210604 | Урсгал засвар | | 132,719,210.0 | 4,998,500.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 252,736,714.2 | 207,245,990.6 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 2,246,138.0 | 35,136,900.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 250,490,576.2 | 172,109,090.6 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | 1,204,851,096.3 | 947,184,016.5 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 560,310,838.4 | 245,598,986.7 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 77,145,011.0 | 45,162,680.0 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | | 567,395,246.9 | 656,422,349.8 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | 725,220,000.0 | 740,600,000.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 725,220,000.0 | 740,600,000.0 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | | 555,683,000.0 | 740,600,000.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 169,537,000.0 | - |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **3** | **9,636,306,623.6** | **10,684,738,972.6** |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | | **470,343,838.4** | **(1,297,507,349.7)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | | 17,598,880.9 | 57,963,770.7 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | | 17,544,880.9 | - |
| 225010 | Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө | | 54,000.0 | 57,963,770.7 |
| **IV** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | | (17,598,880.9) | (57,963,770.7) |
| **V** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | | **452,744,957.5** | **(1,355,471,120.4)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **9,629,928,665.8** | **9,278,106,026.0** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **285,825,141.0** | **375,102,922.0** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 285,825,141.0 | 375,102,922.0 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 285,825,141.0 | 375,102,922.0 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 220,734,841.0 | 345,413,276.0 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 65,090,300.0 | 29,689,646.0 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **9,344,103,524.8** | **8,903,003,104.0** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 9,017,046,500.0 | 8,629,831,900.0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 9,017,046,500.0 | 8,629,831,900.0 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 327,057,024.8 | 273,171,204.0 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 327,057,024.8 | 273,171,204.0 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **8,810,154,956.4** | **9,943,956,767.9** |

| | | | |
|---|---|---|---|
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **8,810,154,956.4** | **9,943,956,767.9** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **8,084,934,956.4** | **9,203,356,767.9** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 6,320,691,699.0 | 7,506,945,955.2 |
| 210101 | Үндсэн цалин | 4,216,085,891.0 | 4,823,779,156.4 |
| 210102 | Нэмэгдэл | 1,571,807,930.9 | 1,798,975,668.9 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 104,226,800.8 | 417,452,802.5 |
| 210104 | Урамшуулал | 428,571,076.4 | 466,738,327.3 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 791,228,905.4 | 935,848,282.5 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 543,126,442.7 | 639,888,104.7 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 64,322,126.7 | 76,444,680.6 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 32,261,951.9 | 38,153,812.4 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 29,799,308.7 | 36,253,048.8 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 121,719,075.5 | 145,108,636.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 232,057,064.8 | 263,172,704.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 88,141,912.8 | 108,499,981.7 |
| 210302 | Түлш, халаалт | 56,602,720.6 | 64,490,044.7 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 87,312,431.3 | 90,182,677.6 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 138,341,685.0 | 4,998,500.0 |
| 210604 | Урсгал засвар | 138,341,685.0 | 4,998,500.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 258,346,714.2 | 207,245,990.6 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,246,138.0 | 35,136,900.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 256,100,576.2 | 172,109,090.6 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 344,268,888.0 | 285,145,335.6 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 255,493,977.0 | 243,694,855.6 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 88,774,911.0 | 41,450,480.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **725,220,000.0** | **740,600,000.0** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 725,220,000.0 | 740,600,000.0 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 555,683,000.0 | 740,600,000.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 169,537,000.0 | - |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **819,773,709.4** | **(665,850,741.9)** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **343,417,000.0** | **186,706,800.0** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **343,417,000.0** | **186,706,800.0** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 343,417,000.0 | 186,706,800.0 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 211,619,800.0 | - |
| 223001 | Бусад хөрөнгө | 131,797,200.0 | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 186,706,800.0 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(343,417,000.0)** | **(186,706,800.0)** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **476,356,709.4** | **(852,557,541.9)** |
| **31** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 990,057,506.8 | 1,466,414,216.2 |
| **31** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 1,466,414,216.2 | 613,856,674.4 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

/төгрөгөөр/

| д/д | Үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцоо | Дахин үнэлгээний нэмэгдэл | Хуримтлагдсан дүн | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 2,227,046,476.6 | 7,138,626,756.0 | 3,482,577,788.7 | 12,848,251,021.3 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| 3 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,227,046,476.6** | **7,138,626,756.0** | **3,482,577,788.7** | **12,848,251,021.3** |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт,бууралт | - | - | - | - |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт,бууралт | - | - | - | - |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| 7 | Тайлант үеийн үр дүн | - | - | - | - |
| 8 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,227,046,476.6** | **7,138,626,756.0** | **3,482,577,788.7** | **12,848,251,021.3** |
| 9 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **2,227,046,476.6** | **7,138,626,756.0** | **3,482,577,788.7** | **12,848,251,021.3** |
| 10 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (23,824,469.0) | (23,824,469.0) |
| 11 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,227,046,476.6** | **7,138,626,756.0** | **3,458,753,319.7** | **12,824,426,552.4** |
| 12 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт,бууралт | - | (1,578,809.1) | - | (1,578,809.1) |
| 13 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| 14 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| 15 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| 16 | Тайлант үеийн үр дүн | - | - | (1,355,471,120.4) | (1,355,471,120.4) |
| 17 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,227,046,476.6** | **7,137,047,946.9** | **2,103,282,199.4** | 11,467,376,622.9 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **I** | **ТАТААС САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **8,903,003,104.0** | **8,903,003,104.0** | **-** | **100.0** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 8,629,831,900.0 | 8,629,831,900.0 | - | 100.0 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 8,629,831,900.0 | 8,629,831,900.0 | - | 100.0 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 273,171,204.0 | 273,171,204.0 | - | 100.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 273,171,204.0 | 273,171,204.0 | - | 100.0 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 371,530,300.0 | 375,102,922.0 | (3,572,622.0) | 101.0 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 314,539,300.0 | 345,413,276.0 | (30,873,976.0) | 109.8 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 56,991,000.0 | 29,689,646.0 | 27,301,354.0 | 52.1 |
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)** | **9,274,533,404.0** | **9,278,106,026.0** | **(3,572,622.0)** | 100.0 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **10,769,605,300.0** | **9,943,956,767.9** | **825,648,532.1** | **92.3** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 9,909,622,700.0 | 9,203,356,767.9 | 706,265,932.1 | 92.9 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 7,764,240,700.0 | 7,506,945,955.2 | 257,294,744.8 | 96.7 |
| 210101 | Үндсэн цалин | 5,125,930,800.0 | 4,823,779,156.4 | 302,151,643.6 | 94.1 |
| 210102 | Нэмэгдэл | 2,197,657,000.0 | 1,798,975,668.9 | 398,681,331.1 | 81.9 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 417,452,802.5 | (417,452,802.5) | - |
| 210104 | Урамшуулал | 440,652,900.0 | 466,738,327.3 | (26,085,427.3) | 105.9 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 970,530,100.0 | 935,848,282.5 | 34,681,817.5 | 96.4 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 659,960,400.0 | 639,888,104.7 | 20,072,295.3 | 97.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 77,642,600.0 | 76,444,680.6 | 1,197,919.4 | 98.5 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 38,821,200.0 | 38,153,812.4 | 667,387.6 | 98.3 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 38,821,200.0 | 36,253,048.8 | 2,568,151.2 | 93.4 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 155,284,700.0 | 145,108,636.0 | 10,176,064.0 | 93.4 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 272,807,600.0 | 263,172,704.0 | 9,634,896.0 | 96.5 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 118,134,800.0 | 108,499,981.7 | 9,634,818.3 | 91.8 |
| 210302 | Түлш, халаалт | 64,490,100.0 | 64,490,044.7 | 55.3 | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 90,182,700.0 | 90,182,677.6 | 22.4 | 100.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | - | - | - | - |
| 210404 | Ном, хэвлэл | - | - | - | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 10,000,000.0 | 4,998,500.0 | 5,001,500.0 | 50.0 |
| 210604 | Урсгал засвар | 10,000,000.0 | 4,998,500.0 | 5,001,500.0 | 50.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 208,445,300.0 | 207,245,990.6 | 1,199,309.4 | 99.4 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 28,500,000.0 | 35,136,900.0 | (6,636,900.0) | 123.3 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 179,945,300.0 | 172,109,090.6 | 7,836,209.4 | 95.6 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 683,599,000.0 | 285,145,335.6 | 398,453,664.4 | 41.7 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 629,255,100.0 | 243,694,855.6 | 385,560,244.4 | 38.7 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 54,343,900.0 | 41,450,480.0 | 12,893,420.0 | 76.3 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 859,982,600.0 | 740,600,000.0 | 119,382,600.0 | 86.1 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 859,982,600.0 | 740,600,000.0 | 119,382,600.0 | 86.1 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 859,982,600.0 | 740,600,000.0 | 119,382,600.0 | 86.1 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | - | - | - |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **186,807,800.0** | (186,807,800.0) | - |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 186,807,800.0 | (186,807,800.0) | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 186,807,800.0 | (186,807,800.0) | - |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **10,769,605,300.0** | **10,130,764,567.9** | **638,840,732.1** | **94.1** |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | **1,466,414,216.2** | **(1,466,414,216.2)** | - |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | **613,856,674.4** | **(613,856,674.4)** | - |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.0 | 1.0 | - | 100.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.0 | 1.0 | - | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 280.0 | 259.0 | 21.0 | 92.5 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.0 | 1.0 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 254.0 | 234.0 | 20.0 | 92.1 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 25.0 | 24.0 | 1.0 | 96.0 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 5,610.0 | 5,570.0 | 40.0 | 99.3 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 5,610.0 | 5,570.0 | 40.0 | 99.3 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 5,610.0 | 5,570.0 | 40.0 | 99.3 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 53,256.4 мянган төгрөгийн 3 алдаа[1] илэрснийг аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 108,114.6 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс 7,173.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, зөрчлийг зогсоох 34,257.0 мянган төгрөгийн албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 77,934.4 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн 108,114.6 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### Дөрөв. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалт тай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үгнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

# 5. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

## Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Өмчийн өөрчлөлтийн тайлангийн өмнөх үеийн хуримтлагдсан дүнг 1,969.9 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн байна. | 1 | 1,969.9 | - | - | 1 | 1,969.9 | 1 | 1,969.9 | - | - | - | - |
| 2 | Татварын тайлангаар цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татвар 12,525.6 мянган төгрөг, суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан татвар 6,155.7 мянган төгрөгөөр тус тус илүү тайлагнасан байна. | 1 | 18,681.3 | - | - | 1 | 18,681.3 | 1 | 18,681.3 | - | - | - | - |
| 3 | Санхүүгийн тайланд тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 32,605.2 мянган төгрөгийн өглөгөөр илүү тайлагнасан байна. | 1 | 32,605.2 | - | - | 1 | 32,605.2 | 1 | 32,605.2 | - | - | - | - |
| | **Дүн** | **3** | **53,256.4** | **-** | **-** | **3** | **53,256.4** | **3** | **53,256.4** | **-** | **-** | **-** | **-** |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| **д/д** | **Зөрчлийн товч утга** | **Нийт зөрчил** | | **Үүнээс** | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | **Төлбөрийн акт** | | **Албан шаардлага** | | **Зөвлөмж** | | **Хариуцлага тооцуулах албан шаардлага** | | **Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал** | |
| | | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Албан тушаалтны тоо** | **Тоо** | **Дүн** |
| 1 | Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлээгүй бичиг хэрэг, аж ахуйн материалын зардалд 5,830.8 мянган төгрөгийг зарцуулсан байна. | 1 | 5,830.8 | - | - | - | - | 1 | 5,830.8 | - | - | - | - |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Ижил төрлийн бараа, ажил үйлчилгээг худалдан авалт хийхдээ тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийж, шууд гэрээ байгуулсан байгуулсан байна. | 1 | 34,257.0 | - | - | 1 | 34,257.0 | - | - | - | - | - | - |
| 3 | Түрээсийн цайны газраас ашиглалтын зардал тооцож аваагүй байна. | 1 | 7,173.1 | 1 | 7,173.1 | - | - | - | - | - | - | - | - |
| 4 | Хичээлийн А, Б байрнууд нь хоорond холбогдсон нэг объектыг 6 харуул, манаач ажиллуулж 23,835.6 мянган төгрөгийн цалин олгож үрэлгэн зарцуулсан байна. | 1 | 23,835.6 | - | - | - | - | 1 | 23,835.6 | - | - | - | - |
| 5 | Ур чадварын нэмэгдэл цалинг 25%-иар хавтгайруулан олгож, төсвийг үрэлгэн зарцуулсан байна. | 1 | 24,807.9 | - | - | - | - | 1 | 24,807.9 | - | - | - | - |
| 6 | Илүү цагаар ажилласан албан хаагчид нэмэгдэл хөлс тооцож олгох хуудсыг хөтлөөгүй 12,210.2 мянган төгрөгийн нэмэгдэл хөлс олгосон байна. | 1 | 12,210.2 | - | - | - | - | 1 | 12,210.2 | - | - | - | - |
| | **Дүн** | **6** | **108,114.6** | **1** | **7,173.1** | **1** | **34,257.0** | **4** | **66,684.5** | **-** | **-** | **-** | **-** |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| д/д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | **Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| 1 | Тайлант онд цахим дэлгүүрээс худалдан авалтыг хийж гүйцэтгээгүй байна. | 1 | 104,980.1 | | | 1 | 104,980.1 | - | - |
| 2 | Шилэн дансны цахим хуудсанд 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,519,846.4 мянган төгрөгийн 1 гүйлгээ, зарлагын 43,677.3 мянган төгрөгийн 7 мэдээллийг ил тод байршуулаагүй байна. | 1 | 1,563,523.7 | | | | | 1 | 1,563,523.7 |
| | **Дүн** | **2** | **1,668,503.8** | | | **1** | **104,980.1** | **1** | **1,563,523.7** |

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**АКТ**

2026. оны 02 дугаар сарын 25 № 04/А0260171 Улаанбаатар хот

НТАГ-2026/299/НА-СТА-ТШ3

## Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Ерөнхий боловсролын 84 дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Түрээсийн цайны газраас нийт 7,173,100.00 (долоон сая нэг зуун далан гурван мянга нэг зуун) төгрөгийн ашиглалтын зардал тооцож аваагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.1-т "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", 41 дүгээр зүйлийн 41.2.1 "*Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх*" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн *21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8 "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:***

1. Ашиглалтын зардал тооцож аваагүй 7,173,100.00 (долоон сая нэг зуун далан гурван мянга нэг зуун) төгрөгийг Нийслэл дэх Төрийн аудитын газрын төрийн сан дахь НТАГ. хүү торгуулийн орлогын MN440090100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Нийслэлийн Ерөнхий боловсролын 84 дүгээр сургуулийн захирал А.Гантулга, ахлах нягтлан бодогч А.Баасанжаргал нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

АХЛАХ АУДИТОР Н.БАТТОГОО

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

14?6110009

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 09/А0260171 Улаанбаатар хот

НТАГ-2026/299/НА-СТА-ТШЗ

**Зөрчил арилгах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Ерөнхий боловсролын 84 дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ижил төрлийн бараа, ажил үйлчилгээг худалдан авалт хийхдээ тендер шалгаруулалтын журмыг зөрчин, 34,257,000.00 (гучин дөрвөн сая хоёр зуун тавин долоон мянга таван зуун) төгрөгийн гэрээ байгуулж, шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "*Хариуцлагатай байх*", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "*Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална*", 10 дугаар зүйлийн 10.3-д "*Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хуваах худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын 4.2.1.9-т "*Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол*" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шууд гэрээ байгуулж, худалдан авалт хийсэн зөрчлийг зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Ерөнхий боловсролын 84 дүгээр сургуулийн захирал А.Гантулга, ахлах нягтлан бодогч А.Баасанжаргал нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

АХЛАХ АУДИТОР Н.БАТТОГОО

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426090027

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 10/А0260171 Улаанбаатар хот

НТАГ-2026/299/НА-СТА-ТШЗ

**Зөрчил арилгах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Ерөнхий боловсролын 84 дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цахим дэлгүүрт байршсан 104,980,100.00 (нэг зуун дөрвөн сая есөн зуун наян мянга нэг зуун) төгрөгийн барааг бусад этгээдээс худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "*Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно*" заасантай тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын 4.2.1.9-т "*Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол*" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цахим дэлгүүрт байршсан барааг бусад этгээдээс худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй арга хэмжээг авч биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Ерөнхий боловсролын 84 дүгээр сургуулийн захирал А.Гантулга, ахлах нягтлан бодогч А.Баасанжаргал нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

АХЛАХ АУДИТОР Н.БАТТОГОО

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

14280900?9